МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
**ЗАХИРАМЖ**

2018 оны 02 сарын 08 өдөр Дугаар А/56 Мандалговь

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 06 өдрийн 03-р дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/251 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Урамшууллын жишиг тогтоох журам"-ын 1.2 дахь заалтыг "Монгол Улсын Засгийн газрын холбогдох яамд, түүний харьяа төрийн байгууллага, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд зарим чиг үүргээ чиглэлийн ТББ-уудаар гүйцэтгүүлэн, хамтран зохион байгуулсан болон тус байгууллагуудын шийдвэр, удирдамж, албан бичиг, баталсан хуваарийн дагуу зохион байгуулагдаж буй уралдаан, тэмцээн, наадмыг улсын хэмжээний уралдаан, тэмцээн, наадам" гэж, мөн 1.3 дахь заалтыг "Тус журмын 1.2-т зааснаас бусад тохиолдолд буюу чиглэлийн ТББ-ууд болон аймгийн Засаг дарга нарын шийдвэрээр зохион байгуулагдаж буй улсын уралдаан, тэмцээн, наадамд хамаарахгүй" гэж өөрчлөн найруулсугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

0230184